



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/255

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 8.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгийн эрсдэлийн “Ерөнхий үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийг нэгдүгээр, “Нарийвчилсан үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийг хоёрдугаар” хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүлэлтийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар (хурандаа Д.Баасансүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/188 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



00002816

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 3.2.-т заасан этгээдийн гүйцэтгэсэн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ (цаашид “ерөнхий үнэлгээ” гэх)-ний тайлан боловсруулахад энэхүү нийтлэг шалгуур үзүүлэлтийг мөрдлөг болгоно.

1.2. Нийтлэг шалгуур үзүүлэлт нь гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайлангийн бүтцийн үлгэрчилсэн загвар, ерөнхий үнэлгээний тайланд зайлшгүй хамаарах үзүүлэлтээс бүрдэнэ.

Хоёр. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайлангийн бүтцийн
үлгэрчилсэн загвар

2.1. Ерөнхий үнэлгээний тайлан дараах бүтэцтэй байна. Үүнд:

2.1.1. нүүр хуудас (ерөнхий үнэлгээ хийлгэж байгаа (засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, стратегийн онц чухал объектын түвшин, салбарын нэр, үнэлгээ хийсэн он, сар, өдөр);

2.1.2. товчилсон үгийн тайлбар;

2.1.3. агуулга;

2.1.4. үнэлгээ хийхтэй холбогдуулан батлагдсан захирамж, тушаалын хуулбар;

2.1.5. ерөнхий үнэлгээ хийсэн багийн бүрэлдэхүүн (ажлын хэсгийн гишүүд тус бүрийн албан тушаалын мэдээлэл, шаардлагатай тохиолдолд гишүүдийн баталгаажуулсан гарын үсэг);

2.1.6. ерөнхий үнэлгээ хийх зорилго;

2.1.7. ерөнхий үнэлгээ хийхэд ашигласан арга, аргачлалын нэр, тайлбар;

2.1.8. нутаг дэвсгэрийн суурь нөхцөл байдал (байгаль, цаг уур, геологийн бүсчлэл, хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт (ангилсан байдлаар), орон нутгийн онцлог, гамшиг ослын давтамж, хохирлын мэдээлэл);

2.1.9. ерөнхий үнэлгээ хийлгэж буй (засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, стратегийн онц чухал объектын түвшин, салбар)-ын талаарх ерөнхий мэдээлэл, танилцуулга;

2.1.10. ерөнхий үнэлгээ хийсэн гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийг тодорхойлсон байдал;

2.1.11. эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн түвшин, зэрэглэл;

2.1.12. гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний нэгдсэн дүгнэлт;

2.1.13. тодорхойлсон гамшгийн төрөл тус бүр дээр гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмж;

2.1.14. хавсралт (үнэлгээний багийн ажил гүйцэтгэх хугацааны зураг, бусад);

2.2. Ерөнхий үнэлгээний тайланд зайлшгүй хамаарах үзүүлэлтүүд. Үүнд:

2.2.1. Эрсдэлийг тодорхойлохдоо тухайн гамшгийн аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхыг хамтад нь, эсхүл тус тусад нь үнэлж тэдгээрийн харилцан хамаарлаар авч үзэж болно.

2.2.2. Цаг үеийн нөхцөл байдал, ерөнхий үнэлгээний зорилго, бусад

холбогдох асуудлаас хамааран зөвхөн аюул, эсхүл өртөх байдал, эмзэг байдал, чадавхыг тодорхойлж болно.

2.2.3. Эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болох гамшгийн аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхад дараах агуулгыг зайлшгүй хамруулсан байх бөгөөд нөхцөл байдлаас хамааран мэдээлэл нэмж болно.

2.2.3.1. аюулыг тодорхойлохдоо тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, аюул, ослын эх үүсвэр, тохиолдох давтамж, хамрах хүрээ, байрлалыг тогтоох, үргэлжлэх хугацаа;

2.2.2.2. өртөх байдлыг тодорхойлохдоо өртөх байдлын хамрах хүрээ, хүний амь нас, эрүүл мэндийн өртөх байдал, эд хөрөнгө, барилга байгууламжийн өртөх байдал;

2.2.2.3. эмзэг байдлыг тодорхойлохдоо эмзэг байдлын хамрах хүрээ, хүн амын нягтрал; хүн амын амь, нас эрүүл мэнд, эд хөрөнгө, барилга байгууламж, дэд бүтэц, үйлдвэрлэл, ажилгүйдэл, ядуурал, нас хүйсийн байдал зэрэг нийгмийн эмзэг байдал;

2.2.2.4. чадавхыг тодорхойлохдоо гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалт, удирдлагын тогтолцоо, хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, хамтын ажиллагаа байгууллага хоорондын уялдаа, дадлага сургууль, сургалт, сургалтын үр дүн, мэдлэг ойлголт, идэвх оролцоо, сурталчилгаа, амшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдал (хүн хүч, багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмж), гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, зарлан мэдээллийн систем, гамшгийн аюулыг бууруулах чиглэлээр байгуулсан биет байгууламж;

2.2.2. Ерөнхий үнэлгээнээс гарах зөвлөмж нь тодорхойлсон эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг тусгасан, хэрэгжих боломжтой, хариуцан хэрэгжүүлэх тал (байгууллага, хүн), хугацаа зэргийг тоймлон тодорхойлсон байх;

2.2.3. Ерөнхий үнэлгээний үр дүнд үндэслэн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай эсэх;

2.3. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайлан баримт бичгийн стандартыг баримталсан, өгүүлбэр, найруулга зүйн алдаагүй байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 11 дугаар сарын 11 ны өдрийн
1/25 тушаалын хоёрдугаар хавсралт



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хуулийн этгээд, стратегийн онц чухал объектын түвшинд, хийсэн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ (цаашид “нарийвчилсан үнэлгээ” гэх)-ний тайланд дүн шинжилгээ хийх, дүгнэх, дүгнэлтийг баталгаажуулахад энэхүү шалгуур үзүүлэлтийг мөрдлөг болгоно.

1.2. Шалгуур үзүүлэлт нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн ерөнхий бүтэц болон гамшгийн төрөл тус бүр дээр аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын үзүүлэлтийг тодорхойлсон үнэлгээ, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хийх дүн шинжилгээнээс бүрдэнэ.

Хоёр. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланд тавигдах шалгуур үзүүлэлт

2.1. Үнэлгээний тайлан дараах бүтэцтэй байна. Үүнд:

2.1.1. нүүр хуудас (үнэлгээ хийсэн байгууллагын нэр, үнэлгээ хийлгэсэн аж ахуй нэгж, байгууллага, хуулийн этгээд, засаг захиргааны нэгжийн нэр, үнэлгээ хийсэн он, сар, өдөр);

2.1.2. товчилсон үгийн тайлбар;

2.1.3. агуулга;

2.1.4. үнэлгээ хийсэн бүрэлдэхүүн боловсон хүчний мэргэшил, боловсролын талаарх мэдээлэл; мэргэшүүлэх сургалтад хамрагдсан эсэх, тус бүрийн үнэлгээ хийсэн гамшгийн төрөл, гишүүдийн гарын үсэг эх хувь (гишүүд тус бүрээр);

2.1.5. нарийвчилсан үнэлгээ хийх зорилго, нарийвчилсан үнэлгээ хийлгэх захиалагч талаас өгсөн гүйцэтгэх ажлын даалгавар;

2.1.6. нарийвчилсан үнэлгээ хийхэд ашигласан арга, аргачлал, эх сурвалж, олон улсад нийтлэг мөрдөж байгаа арга, аргачлалыг ашигласан бол нэр, эх сурвалж;

2.1.7. нарийвчилсан үнэлгээ хийлгэж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хуулийн этгээд, стратегийн онц чухал объектын талаарх мэдээлэл, танилцуулга;

2.1.8. нутаг дэвсгэрийн суурь нөхцөл байдал (байгаль, цаг уур, геологийн бүсчлэл, хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг ангилсан байдлаар статистикт суурилсан мэдээлэл), орон нутгийн онцлог, гамшиг ослын давтамж, хохирлын мэдээлэл;

2.1.9. үнэлгээ хийсэн гамшгийн төрөл тус бүрээр аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын үнэлгээ;

2.1.10. гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, түвшин, эрсдэлийг эрэмбэлсэн байдал;

2.1.11. гамшгийн эрсдэлийн үнэлгээний нэгдсэн дүгнэлт;

2.1.12. гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмж (гамшгийн төрөл тус бүр дээр);

2.1.13. ашигласан материалын жагсаалт;

2.1.14. хавсралт (үнэлгээний багийн ажил гүйцэтгэх хугацааны зураг).

2.2. Тайланг дүгнэхдээ дараах асуудлыг харгалзаж үзнэ. Үүнд:

2.2.1. нарийвчилсан үнэлгээг хийхэд тухайн чиглэлийн мэргэжлийн

боловсон хүчин оролцсон эсэх;

2.2.2. ашигласан багаж төхөөрөмжийн мэдээлэл;

2.2.3. болзошгүй аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхад үндэслэн эрсдэлийг тодорхойлсон эсэх;

2.2.4. гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд гамшгийн төрөл тус бүр дээр гамшгийн цагийн байдал үүсгэсэн эсэх;

2.2.5. нарийвчилсан үнэлгээ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндэслэл болж чадах эсэх,

2.2.6. үнэлгээний үр дүнд тодорхойлсон эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжих боломжтой, оновчтой бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ түүнд шаардагдах зардлыг тооцсон зөвлөмж боловсруулсан эсэх;

2.2.7. гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг практикт, олон улсад нийтлэг мөрдөж байгаа арга, аргачлал, стандартыг баримтлан хийсэн эсэх;

2.2.8. гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайлан баримт бичгийн стандартыг баримталсан, өгүүлбэр, найруулга зүйн алдаагүй, бусад төрлийн тайланг хуулбарлаагүй эсэх.

Гурав. Аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын үнэлгээнд хийх дүн шинжилгээ

3.1. Аюулын үнэлгээнд дараах шалгуур үзүүлэлтийг тооцсон байна. Үүнд:

3.1.1. тохиолдож болох аюулт үзэгдэл, аюул, ослын эх үүсвэр, шалтгаан, нөхцлийг тодорхойлох;

3.1.2. аюул үүсэх магадлал, тохиолдох давтамж;

3.1.3. аюулын хамрах хүрээ, байрлалыг тогтоох;

3.1.4. аюулын үндсэн болон дам нөлөөлөл;

3.1.5. аюулын үргэлжлэх хугацаа;

3.1.6. аюулын түвшин;

3.1.7. аюулын зураглал (Газарзүйн мэдээллийн системийг ашиглах). Гал түймрийн аюулын зураглалыг барилга байгууламжийн давхар тус бүрээр, томоохон зай талбайтай барилгад барилгын эзлэхүүнээр зураглал гаргах.

3.2. Гамшгийн өртөх байдлын үнэлгээнд дараах шалгуур үзүүлэлтийг тооцсон байна. Үүнд:

3.2.1. өртөх байдлын хамрах хүрээ;

3.2.2. хүн амын өртөх байдал;

3.2.3. эдийн засаг, дэд бүтэц, эд хөрөнгө, барилга байгууламжийн өртөх байдал;

3.2.4. байгаль, хүрээлэн буй орчны өртөх байдал;

3.2.5. өртөх байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд;

3.2.6. өртөх байдлын зураглал (Газарзүйн мэдээллийн системийг ашиглах).

3.3. Гамшгийн эмзэг байдлын үнэлгээнд дараах шалгуур үзүүлэлтийг тооцсон байна. Үүнд:

3.3.1. эмзэг байдлын хамрах хүрээ;

3.3.2. хүн амын эмзэг байдал;

3.3.3. удирдлага, зохицуулалтын эмзэг байдал;

3.3.4. эдийн засаг, дэд бүтэц, эд хөрөнгө, барилга байгууламжийн эмзэг байдал;

3.3.5. байгаль, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх, эмзэг байдал;

3.3.6. эмзэг байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд;

3.3.7. эмзэг байдлын зураглал (Газарзүйн мэдээллийн системийг ашиглах). Гал түймрийн эмзэг байдлын зураглалыг 1 давхар барилга, байгууламжид давхрыг бүрэн хамруулж, 2 буюу түүнээс дээш барилгад давхар тус бүрээр зураглалыг гаргасан байх.

3.4. Чадавхын үнэлгээнд дараах шалгуур үзүүлэлтийг тооцсон байна. Үүнд:

- 3.4.1. Гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалт:
 - 3.4.1.1. удирдлагын тогтолцоо;
 - 3.4.1.2. хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт;
- 3.4.2. гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт, шуурхай ажиллагааны чадавх;
- 3.4.3. санхүү, эдийн засгийн чадавх нөөц:
 - 3.4.3.1. гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт (Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах нийт зардал);
 - 3.4.3.2. эдийн засгийн үндсэн үзүүлэлт, үйлдвэрлэл үйлчилгээний зардал, нийт орлого, цэвэр ашиг;
 - 3.4.3.3. хөрөнгө оруулалт;
- 3.4.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт:
 - 3.4.4.1. зарлан мэдээллийн систем;
 - 3.4.4.2. дадлага сургууль, сургалт, сургалтын үр дүн, мэдлэг ойлголт, идэвх оролцоо, сурталчилгаа, мэдээллийн систем;
 - 3.4.4.3. гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдал (хүн хүч, багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмж);
 - 3.4.4.4. аюулыг бууруулах чиглэлээр байгуулсан биет байгууламжийн чанар одоогийн байдал, тэдгээрийн хүчин чадал, ашиглалтын талаарх мэдээлэл.
- 3.5. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр илэрхийлнэ. Үүнд:
 - 3.5.1. Хохирлын таамаглал;
 - 3.5.1.1. хүн ам, дэд бүтэц, нийгэм, эдийн засаг, байгаль, хүрээлэн буй орчин, эвдэрч сүйдэх эд хөрөнгөд учрах хохирлын таамаглал (тухайн гамшгийн төрөл тус бүрээр)-ыг гаргах;
 - 3.5.1.2. амь насаа алдах, гэмтэж бэртэх, нэрвэгдэж болзошгүй хүн амын тоо;
 - 3.5.1.3. эвдрэх, нурах, шатах эд хөрөнгө, барилга, байгууламж, дэд бүтэц;
 - 3.5.1.4. нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хохирлыг урьдчилан тооцоолох.
 - 3.5.2. эрсдэлийн хамрах хүрээ;
 - 3.5.3. эрсдэлийн түвшин;
 - 3.5.4. эрсдэлийн зэрэглэл;
 - 3.5.5. эрсдэлийн зураглал (Газарзүйн мэдээллийн системийг ашиглах).

Дөрөв. Бусад

4.1. Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 5.4, 5.5-д заасан ерөнхий шинжээч, шинжээч, шинжээчийн баг гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, ерөнхий шинжээч дүгнэлт гаргана.

/Энэ заалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/55 дугаар тушаалаар өөрчилсөн/

4.2. Ерөнхий шинжээч, шинжээч, шинжээчийн баг нь хамаарал бүхий хуулийн этгээдийн хийсэн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргавал ашиг сонирхлын зөрчил үүсэх тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага оногдуулна.

4.3. Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нарийвчилсан үнэлгээний тайланг хянуулах тухай албан бичгийн хамт нийслэл, орон нутгийн Онцгой байдлын газарт хүргүүлэх бөгөөд анхан шатны дүн шинжилгээг орон нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний асуудал хариуцсан алба хаагч хариуцна. Тайлан хүлээн авсан өдрөөс анхан шатны дүн шинжилгээг хийх үе шат тус бүрт ажлын 15 хоног, сайжруулалт хийлгэхээр буцаасан тайланг дахин хүлээн авсан өдрөөс ажлын 10 хоногт багтаан дүн шинжилгээ хийнэ. Шаардлага хангасан тайланд дүгнэлт гаргана.

/Энэ заалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/55 дугаар тушаалаар нэмсэн./

4.4. Дүн шинжилгээ хийхдээ нарийвчилсан үнэлгээний тайлантай холбоотой нэмэлт тодруулга, тайлбар, мэдээллийг үнэлгээ гүйцэтгэсэн хуулийн этгээд, үнэлгээ хийлгэсэн захиалагч талаас тухай бүр гаргуулж болно.

/Энэ заалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/55 дугаар тушаалаар нэмсэн./

4.5. Нарийвчилсан үнэлгээний тайланг зааврын дагуу боловсруулаагүй, ирүүлсэн тайлан шалгуур үзүүлэлт, шаардлага хангаагүй гэж үзвэл хуулийн этгээдэд буцаан, сайжруулалт хийх зөвлөмж хүргүүлнэ. Тайлан сайжруулалтыг 3 удаа хангалтгүй ирүүлсэн тохиолдолд тайланг үргэлжлүүлэн хянах боломжгүй тухай хариуг нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэсэн хуулийн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

/Энэ заалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/55 дугаар тушаалаар нэмсэн./

---o0o---